



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Баруунбүрэн сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2023/101-НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.open.audit.mn Сүхбаатар сум 2023 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 70363040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 70363036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn Аудитын гүйцэтгэсэн: Гийк Ом Аудит ХХК Утас: 99052418 Цахим хаяг: cheegii9989@gmail.com</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Аудитын дүгнэлт
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
 - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа
 - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....
 - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....
 - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт
 - 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....
4. Аудитын тайлан
- 4.1 Ерөнхий зүйл
- 4.2 Материаллаг байдал
- 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
- 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
- 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
- 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал
5. Аудитын илрүүлэлт
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
БШУС	Боловсрол, шинжлэх ухааны сайд
БШУГ	Боловсрол, шинжлэх ухааны газар
ЗГ	Засгийн газар
БЕГ	Боловсролын ерөнхий газар
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ХНХС	Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
СӨБ	Сургуулийн өмнөх боловсрол
БШУЯ	Боловсрол, шинжлэх ухааны яам
БҮХТ	Боловсролын үнэлгээний хөгжлийн төв



БАРУУНБҮРЭН СУМЫН ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧ З.НАСАНЖАРГАЛ ТАНАА

**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум
Цагаан Эрэг II баг
Утас: 7036-3040, Факс: (976)-7036-3040
E-mail: Selenge@audit.gov.mn

2023.08.25

№ 27А-2023/101-НА-СТА-ТШЗ

танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Баруунбүрэн сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баруунбүрэн сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Баруунбүрэн сумын 1 дүгээр цэцэрлэг нь 2022 оны үйл ажиллагаанд зарцуулахаар төлөвлөсөн санхүүжилтийг бүрэн төвлөрүүлж, төсвийн гүйцэтгэл 94.1 хувийн биелэлттэй байна.

Тус байгууллага нь хүүхдийн хоолны зардлыг 4,703.0 мянган төгрөгөөр хэмнэснээс голлон шалтгаалж нийт батлагдсан төсөв 5.9 хувиар хэмнэгдсэн байна.

018020117

Аудитын гол асуудал

Баруунбүрэн сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2022 оны нийт төсвийн зарцуулалт, ажил гүйлгээний 73.1 хувийг цалин хөлс, нэмэгдэл урамшил, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардал, 12.2 хувийг байр ашиглалттай холбоотой тогтмол зардал эзэлж байна.

Баруунбүрэн сумын 1 дүгээр цэцэрлэг нь Боловсролын Ерөнхий газрын даргын 2022 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн А/343 дугаар тушаалаар сургалтын байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнгээр 3 дугаар түвшинд үнэлэгдэж урамшуулалд 12,736.7 мянган төгрөгийн санхүүжилт авч зарцуулсан байна.

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайланд танилцуулж, тодруулснаас бусад аудиторын шийдлээр онцлох асуудал байхгүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Ч.ЭНХТУЯА



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Данс	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
I	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	44,956,946.6	63,796,562.0
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ		9,475,176.5
312	Банкинд байгаа бэлэн мөнгө		9,475,176.5
3121	Төгрөг		9,475,176.5
31211	Төрийн сангийн харилцах		9,475,176.5
35	БАРАА МАТЕРИАЛ	44,956,946.6	54,321,385.6
351	Түүхий эд материал	80,600.0	80,600.0
3513	Эм боох материал	80,600.0	80,600.0
3514	Хангамжийн материал	44,876,346.6	54,240,785.6
3541	Бичиг хэргийн материал	144,890.0	1,278,190.0
3542	Аж ахуйн материал	44,424,427.6	48,988,218.0
3546	Хүнсний материал	307,029.0	3,974,377.6
II	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	722,187,817.3	697,344,152.4
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	722,187,817.3	697,344,152.4
392	Биет хөрөнгө	710,612,483.9	686,018,819.0
39201	Барилга, байгууламж, орон сууц	695,278,885.0	695,278,885.0
39202	Хуримтлагдсан элэгдэл	(51,540,316.6)	(72,317,070.5)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	34,799,985.9	35,889,885.9
39206	Хуримтлагдсан элэгдэл	(15,093,107.5)	(19,643,031.4)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	35,578,658.0	38,778,658.0
39208	Хуримтлагдсан элэгдэл	(10,736,885.6)	(13,018,770.8)
39214	Бусад үндсэн хөрөнгө	24,965,469.0	24,965,469.0
39215	Хуримтлагдсан элэгдэл	(3,825,005.4)	(5,100,007.2)
39217	Ном	1,184,801.0	1,184,801.0
393	Биет бус хөрөнгө	11,575,333.4	11,325,333.4
39301	Програм хангамж	1,250,000.0	1,250,000.0
39302	Хуримтлагдсан элэгдэл	(416,666.6)	(666,666.6)
39303	Бусад биет бус хөрөнгө	10,742,000.0	10,742,000.0
III	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	767,144,763.9	761,140,714.5
IV	НИЙТ ӨР ТӨЛБӨР		1,266,126.3
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		1,266,126.3
413	Өглөг		1,266,126.3
4131	Ажилчидтай холбогдсон өглөг		1,266,126.3
V	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	767,144,763.9	759,874,588.2
51	Засгийн газрын хувь оролцоо	767,144,763.9	759,874,588.2
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	79,821,603.0	79,821,603.0
512	Хуримтлагдсан үр дүн	300,012,502.2	292,742,326.6
5121	Өмнөх үеийн үр дүн	300,012,502.2	(467,132,261.6)
5122	Тайлант үеийн үр дүн		759,874,588.2
513	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	387,310,658.6	387,310,658.6
VI	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	767,144,763.9	761,140,714.5

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	443,904,713.1	1,293,758,895.7
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,337,890.0	772,218,163.9
120	Нийтлэг татварын бус орлого	2,337,890.0	772,218,163.9
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,337,890.0	772,218,163.9
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	2,337,890.0	772,218,163.9
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	441,566,823.1	521,540,731.8
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	394,799,000.0	433,124,200.0
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		433,124,200.0
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	394,799,000.0	
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	224,050.0	
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	152,000.0	
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	72,050.0	
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	46,543,773.1	88,416,531.8
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	46,543,773.1	88,416,531.8
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих		
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	430,294,207.8	533,884,307.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	430,294,207.8	533,884,307.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	413,872,057.5	525,605,407.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	286,437,284.7	332,494,882.8
210101	Үндсэн цалин	207,265,734.2	250,625,381.4
210102	Нэмэгдэл	59,678,112.5	75,026,253.0
210104	Урамшуга	19,493,438.0	6,843,248.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	38,305,575.1	42,877,843.9
210201	Тэтгэврийн даатгал	26,733,374.7	29,442,060.7
210202	Тэтгэмжийн даатгал	2,968,649.8	3,452,449.9
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,294,280.9	2,671,240.0
210204	Ажилчиддийн даатгал	573,570.1	664,735.0
210205	Эрүүл мэндийн даатгал	5,735,699.7	6,647,357.5
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	46,020,873.1	62,422,105.4
210301	Гэрэл, цахилгаан	3,504,554.9	6,266,105.7
210302	Түлш, халаалт	38,092,318.2	52,279,999.8
210303	Цэвэр, бохир ус	4,424,000.0	3,876,000.0
2104	Хангамж, бараа материалын зардал	2,943,120.0	4,248,709.6
210401	Бичиг хэрэг	221,850.0	
210402	Тээвэр, шатахуун	846,100.0	
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	927,390.0	205,300.0
210404	Ном, хэвлэл	20,000.0	
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	694,680.0	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	233,100.0	4,000.0
210408	Бараа материал акталсны зардал		4,039,409.6
2105	Нормативт зардал	10,722,141.0	43,050,000.9
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	120,800.0	
210502	Хоол, хүнс	10,601,341.0	43,050,000.9

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	973,750.0	311,000.0
210604	Урсгал засвар	973,750.0	311,000.0
2107	Томилолт, зочны зардал		
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	759,900.0	732,000.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	273,900.0	
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	486,000.0	
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		732,000.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	27,709,413.6	39,468,864.9
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		7,062,240.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,471,650.0	3,335,560.0
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	26,237,763.6	29,071,064.9
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	16,422,150.2	8,278,900.0
2132	Бусад урсгал шилжүүлэг		8,278,900.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		8,278,900.0
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	16,422,150.2	
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	16,422,150.2	
	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		
	Дотоод эхүүсвэрээр		
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	13,610,505.4	759,874,588.2
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН		
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	134,700.0	
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	134,700.0	
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(134,700.0)	
V	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	13,475,805.4	759,874,588.2

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	441,566,823.1	521,540,731.8
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	441,566,823.1	521,540,731.8
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	394,799,000.0	433,124,200.0
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		433,124,200.0
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	394,799,000.0	
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	224,050.0	
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	152,000.0	
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	72,050.0	
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	46,543,773.1	88,416,531.8
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	46,543,773.1	88,416,531.8
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	413,849,123.1	511,475,555.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	413,849,123.1	511,475,555.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	397,426,972.9	503,196,655.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	286,437,284.7	331,324,992.8
210101	Үндсэн цалин	207,265,734.2	249,455,491.4
210102	Нэмэгдэл	59,678,112.5	75,026,253.0
210104	Урамшуулал	19,493,438.0	6,843,248.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	38,305,575.1	42,781,607.6
210201	Тэтгэврийн даатгал	26,733,374.7	29,345,824.4

210202	Тэтгэмжийн даатгал	2,968,649.8	3,452,449.9
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,294,280.9	2,671,240.0
210204	Ажилгүйдлийн даатгал	573,570.1	664,735.9
210205	Эрүүл мэндийн даатгал	5,735,699.7	6,647,357.5
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	46,020,873.1	62,422,105.4
210301	Гэрэл, цахилгаан	3,504,554.9	6,266,105.7
210302	Түлш, халаалт	38,092,318.2	52,279,999.8
210303	Цэвэр, бохир ус	4,424,000.0	3,876,000.0
2104	Хангамж, бараа материалын зардал	4,168,220.0	
210401	Бичиг хэрэг	305,250.0	
210402	Тээвэр, шатахуун	756,700.0	
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	927,390.0	
210404	Ном, хэвлэл	20,000.0	
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	538,880.0	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,620,000.0	
2105	Нормативт зардал	18,839,570.0	46,717,349.5
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	80,800.0	
210502	Хоол, хүнс	10,908,370.0	46,717,349.5
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	7,850,400.0	
2106	Эд хопшил, урсгал засварын зардал	1,186,450.0	490,000.0
210602	Тавилга	47,000.0	
210604	Урсгал засвар	1,139,450.0	490,000.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	973,400.0	962,000.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	487,400.0	
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	486,000.0	
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		962,000.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,495,600.0	18,498,600.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		14,888,600.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,495,600.0	3,610,000.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	16,422,150.2	8,278,900.0
2132	Бусад урсгал шилжүүлэг		8,278,900.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		8,278,900.0
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	16,422,150.2	
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	16,422,150.2	
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	27,717,700.0	10,065,176.5
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	27,717,700.0	590,000.0
22	Биет ба биет бус хөрөнгө худалдан авах	27,717,700.0	590,000.0
	Дотоод эх үүсвэрээр	27,717,700.0	590,000.0
222001	Тоног төхөөрөмж	7,529,700.0	590,000.0
223001	Бусад хөрөнгө	20,188,000.0	
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(27,717,700.0)	(590,000.0)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)		9,475,176.5
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		9,475,176.5

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан /төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Засгийн газрын сан	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	ЗГ-н хувь оролцооны дүн
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	79,821,603.0	387,310,658.6	286,536,696.8	753,668,958.5
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл				
4	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
5	Тайлант үеийн үр дүн			13,475,805.4	13,475,805.4
6	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	79,821,603.0	387,310,658.6	300,012,502.2	767,144,763.9
7	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				7,720,175.6
8	Дахин илэрхийлсэн үлдэгдэл				
9	Тайлант үеийн үр дүн			759,874,588.2	759,874,588.2
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	79,821,603.0	387,310,658.6	292,742,326.6	759,874,588.2

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	525,312,600.0	512,065,555.4	13,247,044.6	97.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	525,312,600.0	512,065,555.4	13,247,044.6	97.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	517,033,700.0	503,786,655.4	13,247,044.6	97.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	338,408,500.0	331,324,992.8	7,083,507.2	97.9
210101	Үндсэн цалин	273,016,500.0	249,455,491.4	23,561,008.6	91.4
210102	Нэмэгдэл	57,354,700.0	75,026,253.0	(17,671,553.0)	130.8
210104	Урамшуулал	8,037,300.0	6,843,248.4	1,194,051.6	85.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	43,658,400.0	42,781,607.6	876,792.4	98.0
210201	Тэтгэрийн даатгал	29,688,200.0	29,345,824.4	342,375.6	98.9
210202	Тэтгэмжийн даатгал	3,492,500.0	3,452,449.9	40,050.1	98.9
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,793,700.0	2,671,240.0	122,460.0	95.6
210204	Ажилгүйдлийн даатгал	699,000.0	664,735.9	34,264.1	95.1
210205	Эрүүл мэндийн даатгал	6,985,000.0	6,647,357.5	337,642.5	95.2
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	62,999,700.0	62,422,105.4	577,594.6	99.1
210301	Гэрэл, цахилгаан	7,671,000.0	6,266,105.7	1,404,894.3	81.7
210302	Түлш, халаалт	52,810,300.0	52,279,999.8	530,300.2	99.0
210303	Цэвэр, бохир ус	2,518,400.0	3,876,000.0	(1,357,600.0)	153.9
2105	Нормативт зардал	51,420,400.0	46,717,349.5	4,703,050.5	90.9
210502	Хоол, хүнс	51,420,400.0	46,717,349.5	4,703,050.5	90.9
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	496,100.0	490,000.0	6,100.0	98.8
210604	Урсгал засвар	496,100.0	490,000.0	6,100.0	98.8

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	962,000.0	962,000.0		100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	962,000.0	962,000.0		100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	19,088,600.0	19,088,600.0		100.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	14,888,600.0	14,888,600.0		100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,200,000.0	4,200,000.0		100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	8,278,900.0	8,278,900.0		100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	8,278,900.0	8,278,900.0		100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	8,278,900.0	8,278,900.0		100.0
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	525,312,600.0	521,540,731.8	3,771,868.2	99.3
131	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	433,124,200.0	433,124,200.0		100.0
131001	Улсын төсвөөс санхүүжих	433,124,200.0	433,124,200.0		100.0
132	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	92,188,400.0	88,416,531.8	3,771,868.2	95.9
132001	Орон нутгийн төсвөөс	92,188,400.0	88,416,531.8	3,771,868.2	95.9
	Мөнгө, түүнтэй адилгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		9,475,176.5	(9,475,176.5)	
5	АЖИЛЛАГСАДЫН ТОО	25.0	25.0		100.0
6	Удирдах ажилтан	1.0	1.0		100.0
7	Гүйцэтгэх ажилтан	8.0	8.0		100.0
8	Үйлчлэх ажилтан	16.0	16.0		100.0
10	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	216.0	216.0		100.0

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сэлэнгэ аймгийн Баруунбүрэн сумын 1 дүгээр цэцэрлэг нь “Бага насны хүүхдийг өөрийн чадвар бүтээлээрээ хөгжих, Хүүхэд бүрийг сургуулийн өмнөх боловсролд бүрэн хамруулж бие даан хөгжих чадварыг бий болгоно” гэсэн эрхэм зорилгын хүрээнд үйл ажиллагаагаа явуулсан байна.

Үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Хүүхэд бүрийг СӨБ-д бүрэн хамруулах, айдас, түгшүүр, сэтгэл зовнил, стрессгүйгээр суралцах, хөгжихөд дэмжлэг үзүүлэх,эрүүл, аюулгүй амьдрах, суралцах зөв дадал хэвшил бий болгох үйл ажиллагааг цаг үеийн нөхцөл байдалтай уялдуулан үр дүнтэй зохион байгуулах,
- Цэцэрлэг сургууль,аж ахуй нэгж байгууллагатай хамтын ажиллагаа тогтоон харилцан туршлага солилцох, хичээл сургалтын үйл ажиллагааг хамтран зохион байгуулах, сургалтын чанар, үйлчилгээний үр ашгийн сайжруулах,
- Хүүхдийн онцлог ялгаатай хэрэгцээнд тулгуурлан хөгжлийг дэмжихэд чиглэсэн төсөлт ажил, арга хэмжээг нутгийн захиргаа,орон нутгийн байгууллага, эцэг эх, асран хамгаалагчдын оролцоотой зохион байгуулах,хамтын ажиллагааг идэвхжүүлэх,

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилтийг баталсан,
- Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдсөн байна.
- Төрийн хэмнэлтийн тухай тухай хууль хэрэгжиж эхэлсэн,
- Төрийн албаны тухай хуульд 2022 оны 04 дүгээр сарын 22, 07 дугаар сарын 05, 11 дугаар сарын 11-нд нэмэлт өөрчлөлт орсон.
- Боловсролын тухай хуульд 2022 онд 3 удаа нэмэлт өөрчлөлт орсон,
- ЗГ-ын 2022 оны 91 дүгээр тогтоолоор батлагдсан “Хувьсах зардлын дундаж норматив, аргачлал батлах тухай” журам хэрэгжиж эхэлсэн,
- ЗГ-ын 2019 оны 472 дугаар тогтоолын 5, 6 дугаар хавсралтаар батлагдсан “Шинжлэх ухааны байгууллага, сургуулийн өмнөх болон бага, дунд боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллагын төрийн үйлчилгээний албан тушаалын цалингийн сүлжээ батлах тухай ” тогтоолд 2022 оны 107 дугаар тогтоолоор батлагдсан “Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг тогтоох тухай” тогтоол, 2022 оны 192 дугаар тогтоолоор нэмэлт өөрчлөлт оруулсан,
- ЗГ-ын 2019 оны 5 дугаар тогтоолын гуравдугаар хавсралтаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын багш, туслах багш, албан хаагчид олгох улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгох” тогтоолд 2022 оны 252 дугаар тогтоолоор нэмэлт өөрчлөлт оруулсан,
- БШУС-ын 2022 оны А/170 дугаар тушаалаар батлагдсан “Хичээл, сургалтын үйл ажиллагааны зардлыг төлөвлөх, хуваарилах заавар”-ыг хэрэгжүүлж эхэлсэн,
- БШУС-ын 2022 оны А/465 дугаар тушаалаар батлагдсан “Ерөнхий боловсролын сургуульд, кабинет, лаборатори, цахим сургалтын танхим байгуулах, ашиглах нийтлэг журам”-ыг шинэчлэн баталсан,
- ХНХС-ын 2021 оны А/192 дугаар тушаалаар батлагдсан “Дундаж цалин хөлс тодорхойлох журам” хэрэгжиж эхэлсэн.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналт, үйл ажиллагааны зохион байгуулалтын хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

Тайлант онд дээд шатны төсвийн захирагчийн зүгээс дотоод аудитын хяналт, шалгалт хийгдээгүй, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл

үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баруунбүрэн сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн, хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

Тус байгууллага нь өмнөх онуудад тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүждэг байсны хувьд Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2020 оны А/202 тоот захирамжаар баталсан Сэлэнгэ аймгийн ТЕЗ-ийн харьяа төсөвт байгууллагууд дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг тайлант онд мөрдөж ирсэн байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн хэдий ч гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжиж байгаа байгууллагын онцлогт тохироогүй, үр дүнд суурилсан төсөвлөлт, санхүүжилт, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний бүртгэлийн талаар нарийн тусгаагүй, өөрөөр хэлбэл боловсролын салбарын онцлогт тохирохгүй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баруунбүрэн сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 6,004.0 мянган төгрөгөөр буюу 0.8 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/мянган төгрөгөөр/	
			Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
	Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			9,475.2	9,475.2
Авлага				
Бараа материал		44,956.9	54,321.4	9,364.4
Үндсэн хөрөнгө		722,187.8	697,344.2	(24,843.7)
Нийт хөрөнгө		767,144.8	761,140.7	(6,004.0)
Өр төлбөр			1,266.1	1,266.1
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/		767,144.8	759,874.6	(7,270.2)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн		767,144.8	761,140.7	(6,004.0)

Тайлант жилийн үйл ажиллагааны зардлын хэмнэлт 9,475.2 мянган төгрөгийг Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралт “Хувьсах зардлын

дундаж нормативаар төсөв хуваарилах, санхүүжүүлэх аргачлал"-ын 8.7-д "Боловсролын сургалтын байгууллагын жилийн эцсийн дансны үлдэгдлийг дараагийн төсвийн жилд шилжүүлнэ" гэж заасны дагуу төрийн сангийн харилцах дансанд үлдэгдлээр тайлагнагдсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 54,321.4 мянган төгрөг болж 9,364.4 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 61,961.6 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч, аймгийн БШУГ-аас 323.5 мянган төгрөгийн кварцын гэрэл, эцэг эхчүүдийн хандиваар 1,050.0 мянган төгрөгийн материал зэрэг нийт 1,373.5 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй орлогоор бүртгэж авсан бөгөөд үйл ажиллагаанд 53,970.6 мянган төгрөгийн хөрөнгийг зарцуулсан зэрэг нь нөлөөлсөн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл *ланхны өртгөөр* 808,089.6 мянган төгрөг болж 4,289.9 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 590.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авч, иргэд аж ахуйн нэгжээс 499.9 мянган төгрөгийн, аймгийн БШУГ-аас 3,200.0 мянган төгрөгийн нийт 3,699.9 мянган төгрөгийн үнэ төлбөргүй тоног төхөөрөмж авсан зэргээс шалтгаалсан байна.

Ажиллагсадтай холбоотой 1,266.1 мянган төгрөгийн өр төлбөр шинээр үүссэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 759,874.6 мянган төгрөг болж мянган төгрөгөөр 7,270.2 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх болон тайлант үеийн үр дүнгээс шалтгаалсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 495,255.6 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлж батлуулсан байна.

2022 оны 11 дүгээр сард хийсэн төсвийн зохицуулалтаар байгууллагын үйл ажиллагааг хэвийн явуулахад шаардагдах бараа үйлчилгээний бусад зардал 30,057.0 мянган төгрөгөөр төсвийг нэмэгдүүлж улсын төсвөөс 433,124.2 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 92,188.4 мянган төгрөг нийт 525,312.6 мянган төгрөгийн эх үүсвэрийг баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 9 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 433,124.2 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 92,188.4 мянган төгрөг нийт 525,312.6 мянган төгрөгийн эх үүсвэрийг урсгал үйл ажиллагаанд захиран зарцуулахаар төлөвлөгдсөн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 512,065.6 мянган төгрөг буюу 95.5 хувьтай байгаа нь цалин хөлс, нэмэгдэл урамшлын зардлыг 7,083.5 мянган төгрөгөөр, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 876.7 мянган төгрөгөөр, тогтмол зардал 577.6 мянган төгрөгөөр, эд хогшил худалдан авах зардал 6.2 мянган төгрөгөөр, хүүхдийн хоолны зардлыг 4,703.0 мянган төгрөгийг тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

		/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр	д/д	Арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	зөрүү	Биелэлт
1	71801 Сургуулийн өмнөх боловсрол	1	81605-Эрүүл мэндийг дэмжих	1,300.0	1,300.0	-	100.0
		2	81807- Цэцэрлэгийн хүүхдийн хоол	51,420.4	46,717.3	(4,703.1)	90.9
		3	81816-Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	1,794.8	1,794.8	-	100.0
		4	81823- Боловсролын байгууллагын багш	1,300.0	1,300.0	-	100.0
		5	81834- Боловсролын стандарт сургалт	317,228.6	309,649.4	(7,579.2)	97.6
		6	81835-Сургалтын хэвийн үйл ажиллагаа	63,268.3	62,887.5	(380.8)	99.4
		7	80111-Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	63,495.8	62,912.1	(583.7)	99.1
		8	80112-Нийтлэг үйлчилгээ	25,504.7	25,504.4	(0.3)	100.0
		Нийт		525,312.6	512,065.6	(13,247.0)	97.5

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус байгууллагын нэмэлт санхүүжилтийн 100130515402 тоот дансанд орлого, зарлагын гүйлгээ хийгдээгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баруунбүрэн сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2022 оны 12

дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн байгууллагын санхүүгийн сахилга батыг дээшлүүлж, төсвийн хөрөнгийг хэмнэлттэй, үр, ашигтай зарцуулахтай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу “Пийк Ом Аудит” ХХК-ийн аудитор Б.Наранчимэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Баруунбүрэн сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Пийк Ом Аудит ХХК-д 2023 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 26 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБӨУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн шатны материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 286,632.7 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 2,866.3 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Боловсролын ерөнхий газраас нийт боловсролын байгууллагуудад 2022 оны 04, 09 дүгээр саруудад төрийн хэмнэлтийн тухай хууль болон ЗГ-ын 2022 оны 203 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах, төсвийн хэмнэлтийн горимоор ажиллах, орон тоог хязгаарлах, төрийн үйл ажиллагааг цахимжуулах, бараа үйлчилгээний зардлыг бууруулах, зөвлөмжийг хүргүүлсэн байна.

Баруунбүрэн сумын 1 дүгээр цэцэрлэг нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийг дараах байдлаар хэрэгжүүлжээ. Үүнд:

- Боловсролын салбарын үр дүнд суурилсан санхүүжилтийг нэвтрүүлж батлагдсан орон тоогоор бус гүйцэтгэлээр санхүүжүүлсэнтэй холбоотойгоор цалин, ажил олгогчоос төлөх НДШ, үдийн цай хөтөлбөр, тогтмол зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас нийт 13,247.0 мянган төгрөгийн хэмнэлтийг бий болгожээ.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд сургуулийн өмнөх боловсролын байгууллагын мэдээлбэл зохих 20 төрлийн 170 мэдээллээс 11 мэдээллийг хугацаа хоцроосон байна. Үүнд:

- Төсөв гүйцэтгэлтэй холбоотой мэдээллийг 6 удаа хугацаа хоцроож мэдээлсэн,
- Хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалттай холбоотой мэдээллийг 3 удаа хугацаа хоцроож мэдээлсэн,
- Бусад мэдээллийг 2 удаа хугацаа хоцроосон байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1 дэх “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.1.10: “Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэх.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

“Гийк Ом Аудит” ХХК-ийн 2022 оны 11 дүгээр 02-ны 193 дугаар албан бичгээр “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” захидлыг хүргүүлсэн бөгөөд тус байгууллагын 2022 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй 19,745.0 мянган төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй ажиллах талаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	2	19,745.0			
Нийт дүн	2	19,745.0			

Өмнөх аудитаар өгсөн холбогдох хууль, тогтоомжийн дагуу төлбөрийн цахим баримтыг үндэслэж, ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэж байх зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд давтан гаргасан тул МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1 дэх “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.1.10: “Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэсэн заалтын дагуу **албан шаардлага** хүргүүлэхээр шийдвэрлэв.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараах асуудлууд нь тухайн төсвийн захирагчийн бус дээд шатны төсвийн захирагчийн шийдвэрээр хэрэгжсэн учир Баруунбүрэн сумын 1 дүгээр цэцэрлэгийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар зөрчлөөр тооцоолгүйгээр дээд шатны төсвийн захирагчийн санхүүгийн тайланд хийх аудитын анхааралд хандуулж байна. Үүнд:

1. Дээд шатны төсөв захирагчаас төсвийг зардлын эдийн засгийн ангиллаар нь бус “бараа үйлчилгээний бусад зардал” гэсэн ангиллаар бөөнд нь тусган, төлөвлөж, баталж байгаа нь төсвийг зардлын бүлэг, зүйлээр төлөвлөж, зарцуулах, зарцуулалтад хяналт тавих зарчмыг алдагдуулж байна. Иймд төсвийг бодит гүйцэтгэлтэй нь уялдуулан зардлын бүлэг, зүйл бүрээр төлөвлөж, зарцуулан гүйцэтгэж байх шаардлагатай байна.
2. Сангийн яамны 2022 оны 02 дугаар сарын 28-ны “Чиглэл хүргүүлэх тухай” албан бичгээр байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансыг хааж нэмэлт санхүүжилттэй холбоотой гүйлгээг урсгал дансаар дамжуулан “Нэмэлт - Дээд шатны төсвөөс хуваарилсан” гэсэн зориулалтаар, төсөвт байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлого / 120010 / ангиллаар гүйцэтгэхээр чиглэл хүргүүлсэн байна. Нэмэлтээр хуваарилах төсвийн эх үүсвэрийг төсвийн санхүүжилтийн эх үүсвэр болгон төлөвлөж байгаагаас гүйцэтгэлээр уг санхүүжилт хуваарилагдаагүй тохиолдолд төсвийн санхүүжилтийн төлөвлөгөө тасарснаар тайлагнагдах эрсдэлийг үүсгэж байна. Иймд дээд шатны төсвөөс хуваарилах нэмэлт төсвийг төсвийн санхүүжилт хэлбэрээр урьдчилан төлөвлөж, батлалгүйгээр санхүүжилт ирсэн тухай бүр тухайн санхүүжилтийн дүнгээр зарцуулах эрх тавих нь зүйтэй юм.
3. Тус байгууллага нь өмнөх жилүүдэд тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүждэг байсан учир Сэлэнгэ аймгийн ЗД-ын 2020 оны 7 дугаар сарын 16-ний өдрийн А/202 дугаар захирамжаар баталсан “Сэлэнгэ аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн багцад хамаарах төсөвт байгууллагуудад мөрдөх

нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг мөрдөж ирсэн байна. Бүртгэлийн үйл ажиллагаанд мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн хэдий ч боловсролын байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирохгүй учир төсвийн боловсролын салбарын ерөнхийлөн захирагчийн боловсруулсан НБББББ-ыг мөрдөх нь зүйтэй юм.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар бараа материалыг орлого авалгүй шууд зардлаар бүртгэсэн 3,151.4 мянган төгрөгийн алдааг залрууллаа.

Аудитаар нийт **2,458.1** мянган төгрөгийн зөрчил¹ илрүүлж албан шаардлага хүргүүллээ.

5.1 Албан шаардлага

1. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулж цахим системд шивэх талаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүйгээс 1,192.0 мянган төгрөгийн зөрчлийг давтан гаргасан байна.

Энэ нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.5 дахь *“Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй”*, гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1 дэх “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.1.10: *“Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол”* гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэх.

2. Төлбөр тооцоог урьдчилан хянаагүйн улмаас ажилчидтай холбоотой цалин, НДШ-ийн 1,266.1 мянган төгрөгийн өр төлбөр үүсгэсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь *“Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”*, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь *“дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”* гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг зохистой удирдаж, төлбөр тооцоог урьдчилан хянасны үндсэн дээр өр төлбөр үүсгэхгүй ажиллах албан шаардлага хүргүүлэх.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруул аагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шууд зөрдлээр бүртгэсэн	1	3,151.4			1	3,151.4	1	3,151.4				
Дүн	1	3,151.4			1	3,151.4	1	3,151.4				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Худалдан авалтыг цахим баримтаар баталгаажуулаагүй	1	1,192.0			1	1,192.0						
2.Өр төлбөр үүсгэсэн	1	1,266.1			1	1,266.1						
Дүн	2	2,458.1			2	2,458.1						

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Мэдээлэл хоцроосон	11				11			
Дүн	11				11	-		
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн	11				11			